



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, БҮРТГЭЛИЙГ
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ОРА-2023/28-13-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Нармандах Утас: 70353088
Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Буян-Ундрах Утас: 70355805
Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор Б.Бямбаогтох

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	4
Ерөнхий мэдээлэл.....	7
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна.....	8
1.1. Төсөл арга хэмжээг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.	8
1.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан ч зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ баталдаг зөрчил давтан гарсаар байна.....	9
БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, он дамжин гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтад анхаарах шаардлагатай байна. ...	12
2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	12
2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байна.	13
2.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна.	16
2.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.	17
2.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах комисс хангалтгүй ажилласнаас чанаргүй барилга, дутуу тоног төхөөрөмж хүлээн авч байна. .	18
БҮЛЭГ 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хөрөнгийн бүртгэл болон он дамнан гүйцэтгэж буй ТАХ-нд анхаарах шаардлагатай байна.....	21
3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг нэмэгдүүлэх, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.	21
3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь он дамнан гүйцэтгэж байгаа, санхүүжилт болон хөрөнгийн бүртгэл хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөө буурч байна.	23
ДҮГНЭЛТ:.....	27
Холбогдох байгууллагын санал:.....	29
Саналд өгсөн тайлбар.....	34

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТ	Зураг төсөв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УДДТ	Ус, дулаан дамжуулах төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХББЗА ОНӨААТҮГ	“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЭШУТП ОНӨААТҮГ	“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ	11
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2-оос дээш жил үргэлжилж байгаа төсөл арга хэмжээний жагсаалт	12
Хүснэгт 3	Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2022 онд олгосон төсвийн санхүүжилт	16
Хүснэгт 4	Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн	21
Хүснэгт 5	ОНХО-аар хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны төрөл	24

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хийгдсэн ТАХ нийт баталсан хөрөнгө оруулалтын тоонд эзлэх хувь	22

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан Үндэсний Аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, ХББЗА ОНӨААТҮГ-ын болон УТХО-н 28 ТАХ, ОНХО-н 199 ТАХ-ний баримт материалыг хамруулсан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг АДБОУБ-с хүлээн зөвшөөрсөн АОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Бямбатогтох, Г.Даваасүрэн, Ц.Одгэрэл нар 2023 оны 01

дүгээр сарын 30-ний өдрөөс эхлэн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээл:

Хөрөнгө оруулалтын мэдээллийн сан үүсгээгүй, аудитын багийг төлөвлөлтийн үе шатны мэдээллээр бүрэн хангаагүй, улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын судалгааг үнэн зөв, иж бүрэн шаардсан хугацаанд гаргаж ирүүлээгүй зэрэг нь хүндрэл учруулж байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Орхон аймагт нийт 83,188.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 21,353.6 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 28 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталжээ. Улсын хэмжээнд хэрэгжих ТАХ-ээс Орхон аймагт 34,741.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Үүнээс аймагт эрх шилжсэн 55,625.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ, эрх шилжээгүй 62,304.4 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн ИТХ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээг 3 удаа тодотгож баталжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-н 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын хавсралтаар тодотгон баталж, 76,252.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 59,713.6 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 385 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 18 ТАХ-д худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 259 ТАХ-д худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 251 худалдан авах ажиллагаа амжилттай болж, 6 гэрээ байгуулаагүй байна.

Эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 14 ТАХ-нд 12,959.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 106.9 сая төгрөгийг БШУЯ-ны дансанд төвлөрүүлсэн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн 40,781.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, захиалагчийн болон зохиогчийн хяналтын 1,582.2 сая төгрөгийг хяналтын болон барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэн, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8,136.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Эрх шилжсэн ТАХ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн ТАХ-ний захиалагчийн болон зарим ТАХ-ний зохиогчийн хяналтыг аймгийн ХББЗА ОНӨААТҮГ гүйцэтгэж, харин эрх шилжээгүй ТАХ-ний захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ, Барилгын хөгжлийн төвтэй хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

НЭГ. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна.

1.1 Төсөл арга хэмжээг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 28 ТАХ-ээс 18 ТАХ шилжих, 10 ТАХ шинээр хэрэгжихээр МУ-н 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан байна. Баталсан хөрөнгө оруулалтаас 22 ТАХ нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцэж, 1 ТАХ нь нийцээгүй байна. Үүнд:

- Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/, /2022 он/

Харин 5 ТАХ нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг батлагдахаас өмнө хэрэгжиж эхэлсэн байна. Үүнд:

- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/, /2018 он/
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/, /2020 он/
- Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/, /2019 он/
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.6 км /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Эрдэнэ баг/, /2019 он/
- Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/, /2018 он/

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй 19 ТАХ-г нийцүүлэн төлөвлөж, 4 ТАХ-г нийцүүлэлгүй төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 28 ТАХ-ээс 19 ТАХ нь “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй нийцэж, 4 ТАХ нийцээгүй байна. Нийцээгүй ТАХ-г тодруулбал:

- Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Орхон/, /2022 он/,
- Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян Өндөр, Жаргалант сум/, /2022 он/,
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/, /2021 он/,
- Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/, /2022 он/,

Харин хөтөлбөр батлагдахаас өмнө хэрэгжиж эхэлсэн 5 ТАХ байна. Үүнд:

- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/, /2019 он/,
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/, /2020 он/,
- Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/, /2019 он/,

- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.6 км /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Эрдэнэ баг/, /2019 он/,
- Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/, /2019 он/

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдааг хангасан ч хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг бий болгож чадахгүй байна.

Хөрөнгө оруулалтын 19 ТАХ нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, сургууль цэцэрлэг барьж байгуулах, шинжлэх ухаан инновацын төв байгуулахаар төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын бодлогын зорилго, зорилтыг улс, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдааг хангасан байна.

2022 онд 2 цэцэрлэг, 1 сургууль ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлснээр нийт 128 ажлын байр нэмэгдсэн байна.

Харин тоног төхөөрөмж нийлүүлэх 6 ТАХ-г хэрэгжүүлэхдээ төлөвлөлтийн дагуу гүйцэтгээгүй, өөр зориулалтаар ашигласан нь эерэг өөрчлөлтийг бий болгож чадахгүй байна. *Тухайлбал:*

- Бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт эзэд" хөтөлбөр *,/нийлүүлсэн тоног төхөөрөмжийг төрийн байгууллагууд болон бусад төрийн бус байгууллага, УИХ гишүүний ажлын албанд олгосон/*
- Олон талт түншлэлийг хөгжүүлэх "Жишиг баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/, */Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг иргэдэд шалгуургүй олгосон, ажлын байр нэмэгдсэн эсэх нь тодорхойгүй/*
- Олон талт түншлэлийн хүрээнд "Жишиг эко баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/, */Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг иргэдэд шалгуургүй олгосон, ажлын байр нэмэгдсэн эсэх нь тодорхойгүй/*
- Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум/, */Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг иргэдэд шалгуургүй олгосон, ажлын байр нэмэгдсэн эсэх нь тодорхойгүй/*
- Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон/, */Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг иргэдэд шалгуургүй олгосон, ажлын байр нэмэгдсэн эсэх нь тодорхойгүй/*
- Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/, */Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг иргэдэд шалгуургүй олгосон, ажлын байр нэмэгдсэн эсэх нь тодорхойгүй/*

1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан ч зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ баталдаг зөрчил давтан гарсаар байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ нь хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 19 барилга байгууламж, 8 тоног төхөөрөмж, 1 ТЭЗҮ боловсруулах нийт 28 ТАХ төлөвлөсөн нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалт

байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн мэдээлэл хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн мэдээллийг pimis.publicinvestment.gov.mn цахим системээр 2019 оноос эхлэн гүйцэтгэсэн хэдий ч программ шинэчлэлээс шалтгаалан архив үүсээгүй, дэлгэрэнгүй мэдээлэл болон Сангийн яам хэрхэн хяналт хэрэгжүүлснийг нягтлах боломжгүй байлаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан төсөл, арга хэмжээ бүрээр хийсэн судалгаа, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоолол, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол болон холбогдох мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сан үүсгэх шаардлагатай байна.

Иймд хөрөнгө оруулалтын мэдээллийн сан үүсгээгүй, аудитын явцад аудитын багийг төлөвлөлтийн үе шатны мэдээллээр бүрэн хангаагүй, улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын судалгааг үнэн зөв, иж бүрэн шаардсан хугацаанд гаргаж ирүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Зураг төсөл боловсруулж, батлуулаагүй 2 ТАХ-г төлөвлөн, баталсан байна.

Шинээр хэрэгжих 10 ТАХ-ээс зураг төсөл боловсруулах, техникийн нөхцөл шаардлагатай 4 ТАХ байна. Үүнээс 2 ТАХ-ний зураг төсөл, 1 ТАХ-ний техникийн нөхцөлийг 2022 оны Төсвийн тухай хууль баталсны дараа боловсруулж баталжээ. Тухайлбал:

- Сум, багийн орчныг сайжруулах тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/, /зураг төсөл-2022.03.09-ны өдөр боловсруулсан, цахилгааны техникийн нөхцөл-2022.01.31, холбооны техникийн нөхцөл-2022.01.26-ны өдөр олгосон/,
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/, /зураг төсөл-2022.01.10-ны өдөр боловсруулсан/

Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгө ашиглалттай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний төсвийн төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоолол, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй байна.

Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ ТАХ-ний урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоолоогүйгээс 2022 онд 293.4 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна. Уг ТАХ нь хуучин сургуулийн барилгыг нурааж 4 блок 960 хүүхдийн сургууль баригдаж байгаа бөгөөд барилга баригдаж дуусах хүртэлх хугацаанд хувийн барилгыг сарын 58.7 сая төгрөгөөр түрээсэлж үйл ажиллагаа явуулж байна. Барилгын санхүүжилт Төсвийн тухай хуулиар бүрэн батлагдахгүйгээс барилга царцаагдах, улсын төсвөөс түрээсийн төлбөрийн урсгал зардал өндөр гарч төсөвт

ачаалал үүсэхээр байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан ч Төсвийн тухай хуульд нийцүүлэлгүй төлөвлөсөн байна.

Эрх шилжсэн 18 ТАХ-ний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн хуульд заасан журмыг баримтлан 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж, гэрээ байгуулан ажилласан байна.

Гэрээний үүргээ биелүүлээгүй, хуулиар баталснаас хойш нэмэгдүүлэн баталсан ТАХ байхгүй байна.

Эрх шилжсэн худалдан авах ажиллагаанаас 1,579.3 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д шинээр эхлэх ТАХ-ний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар заасан байтал 2022 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 28,644.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний тайлант онд санхүүжих дүн хэрэгжих хугацаанд хуваарилсан хэмжээнээс 5,944.9 сая төгрөгөөр бууруулж баталсан нь хуулиар тодорхойлсон хугацаанд барилга байгууламж ашиглалтад орохгүй байх эрсдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

д/д	ТАХ-ний нэр	хэрэгжих хугацаа		Баталсан		Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Зөрүү /тайлант онд санхүүжих-тэнцүү хуваарилсан байх/
		Эхлэх	Дуусах	төсөвт өртөг	тайлант онд санхүүжих дүн		
1	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/	2022	2023	5,000.0	800.0	1,666.7	(866.7)
2	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян Өндөр, Жаргалант сум/	2022	2023	3,000.0	2,000.0	1,000.0	(1,000.0)
3	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	2022	2024	8,233.1	980.0	2,744.4	(1,764.4)
4	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/	2022	2023	7,411.7	1,500.0	2,470.6	(1,647.1)

5	Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/	2022	2023	5,000.0	1,000.0	1,666.7	(666.7)
ДҮН				28,644.8	6,280.0	9,548.4	(5,944.9)

Шилжих ТАХ-ээс хоёроос дээш жил үргэлжилж байгаа нийт 18,584.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 барилга байгууламжийг үргэлжлүүлэн барихаар төсөвлөгдсөн байна.

Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2-оос дээш жил үргэлжилж байгаа төсөл арга хэмжээний жагсаалт

№	Эхэлсэн хугацаа /оноор/	Үргэлжилж байгаа хугацаа /жилээр/	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	2013	10	2	8,682.8
2	2014	9	1	1,651.4
3	2018	5	2	4,200.0
5	2020	3	2	4,050.0
Нийт дүн			7	18,584.2

Дээрх ТАХ-үүд тухайн онд баталсан санхүүжилт хүрэлцээгүй, дараа оны Төсвийн тухай хуульд баталдаггүй зэрэг шалтгаанаар үргэлжилж байгаа нь барилгын чанар муудах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх эрсдэлтэй байна.

ХОЁР. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, он дамжин гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтад анхаарах шаардлагатай байна.

2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 10 ТАХ-ний худалдан авах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх эрхийг холбогдох салбарын сайдын багцаас аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасны дагуу эрхийг шилжүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Шинээр хэрэгжих 10 ТАХ-ний 9 ТАХ нь нээлттэй тендер шалгаруулалт, 1 ТАХ түлхүүр гардуулах нөхцөлөөр худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулжээ.

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 10 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 1 үнэлгээний хороо байгуулжээ.

Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын

төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж баталсан байна.

Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдийг өөрчилдөггүй, өөрийн эрх хэмжээний хүрээнд тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, үе шатны ажлын хуваарь, урилга зэрэг хэсгүүдэд өөрчлөлт оруулдаг байна.

Тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.

Гүйцэтгэгчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Зууны мэдээ сонинд нийтлүүлэн, tender.gov.mn болон erdenet.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох олон талт түншлэл цахим хөтөлбөрийн гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад оролцсон Бодь электроникс ХХК-аас ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу гомдол гаргаж, Сангийн яам хянаж, Монтех дистрибьюшн ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон албан бичгийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна. Уг гомдлын шийдвэрийг үнэлгээний хороо дахин хэлэлцэж Бодь электроникс ХХК нь тендерийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.4 дэх хэсгийн дагуу тендерээс татгалзах шийдвэр гаргаж, Монтех дистрибьюшн ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байна.

Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, баталсан зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа ч санхүүжилтээс шалтгаалан он дамнан гүйцэтгэж байна.

Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, баталсан зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа ч 2022 онд 8 ТАХ анх байгуулсан гэрээний хугацаандаа гүйцэтгэх боломжгүйгээс гэрээг сунгасан байна. Үүнээс он дамнан гүйцэтгэх 1 ТАХ, гэрээ сунгасан ч санхүүжилтээс шалтгаалан он дамнасан 2 ТАХ байна. *Тухайлбал:*

- Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/, /гэрээний сунгалт 2022.12.30-2023.12.21-ний өдөр хүртэл, одоог болтол ажил гүйцэтгээгүй/,
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/,

/гэрээний сунгалт 2022.08.30-2022.12.30-ны өдөр хүртэл, олгосон санхүүжилтийн дагуу ажил гүйцэтгэсэн, ажлын гүйцэтгэл 80%/,

- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/, /гэрээний сунгалт 2022.06.02-2022.12.31-ний өдөр төсвөөс шалтгаалан ажил удааширсан, 2022 онд 315.0 сая төгрөгөөр төсөв нэмэгдүүлж баталсан, ажлын гүйцэтгэл 61.5%/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдээгүй байна.

Нийлүүлсэн тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байгаа ч 409.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг дутуу хүлээн авсан байна.

Нийлүүлсэн тоног төхөөрөмж баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна.

Харин 409.6 сая төгрөгийн 48 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй байхад “тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт” үйлдэн санхүүжилт олгосонд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

- Олон талт түншлэлийг хөгжүүлэх "Жишиг баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/, /Гутлын толгой хэвлэгээний машин нэг бүрийн үнэ 9.4 сая төгрөгийн үнэтэй 20 ширхэг дутуу нийлүүлсэн/
- Олон талт түншлэлийн хүрээнд "Жишиг эко баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/, /Гутлын толгой хэвлэгээний машин нэг бүрийн үнэ 7.9 сая төгрөгийн үнэтэй 28 ширхэг дутуу нийлүүлсэн/

ТЭЗҮ-н гүйцэтгэл гараагүй, хүлээн авах акт үйлдээгүй байхад ТЭЗҮ-д тусгасан тоног төхөөрөмжийг ашигласан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 800.0 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 1 ТЭЗҮ боловсруулах ТАХ баталсан ч энэ онд гүйцэтгэл гараагүй байна.

Эрдэнэт ШУТП-н ТЭЗҮ техникийн даалгаварт 2022 онд ТЭЗҮ боловсруулах, батлагдсан ТЭЗҮ -ийн дагуу тоног төхөөрөмж нийлүүлэхээр тусгасан байна.

Төсвийн тухай хуулиар баталсан төсөвт тохирсон ТЭЗҮ, тоног төхөөрөмж нийлүүлсэн ч аймгийн ОНӨГ тоног төхөөрөмж хэт өндөр үнэтэй, хүлээн авах боломжгүй гэсэн тайлбар өгсөн. Харин Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ нь тус тоног төхөөрөмжийг хүлээн авч байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, 57 иргэнд “Тоног төхөөрөмж ашиглах, ашиглуулах гэрээ” байгуулан олгосон байна.

Иймд тоног төхөөрөмж хүлээн авах акт үйлдээгүй, данс бүртгэлд тусгаагүй байхад тоног төхөөрөмжийг иргэдэд тараасан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан 10 ТАХ, хуулиар батлаагүй царцаагдсан 5 ТАХ байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан 10 ТАХ он дамжихаар байна. Тухайлбал:

- Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/, /2020-2022 онд дуусах/,
- Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/, /2018-2023 он/,
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/, /2020-2022 он/,
- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/, /2018-2023 он/,
- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/, /2013-2022 он/,
- Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/, /2018-2023 он/,
- Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/, /2022-2023 он/,
- Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/, /2022-2024 он/,
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/, /2022-2023 он/,
- Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/, /2022-2023 он/

Дээрх ТАХ-ээс 7 ТАХ нь 2023-2024 онд хэрэгжиж дуусахаар батлагдаж, 3 ТАХ нь санхүүжилтээс шалтгаалан 2022 онд хэрэгжиж дуусаагүй байна.

Харин 2022 оны Төсвийн тухай хуульд төсөв батлагдаагүй өмнөх онд гүйцэтгэж байсан 7,062.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ царцагдсан байна.
Тухайлбал:

- Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/, /2019-2021 онд хэрэгжихээр баталсан, ажлын гүйцэтгэл 63 хувьтай/,
- Хүүхдийн хөгжил хамгааллын төвийн барилга / Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг /, /2020-2021 онд хэрэгжсэн ажлыг гүйцэтгэл 70 хувьтай, баталсан төсөвт тохирох ажлыг гүйцэтгэсэн/,
- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/, /2019-2021 онд хэрэгжсэн, ажлын гүйцэтгэл 50 хувьтай баталсан төсөвт тохирох ажлыг гүйцэтгэсэн/,
- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/, /2020-2021 онд хэрэгжсэн, ажлын гүйцэтгэл 60 хувьтай, баталсан төсөвт тохирох ажлыг гүйцэтгэсэн/,
- Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/, /2020-2021 онд хэрэгжсэн, ажлын гүйцэтгэл 76 хувьтай, баталсан төсөвт тохирох ажлыг гүйцэтгэсэн, үнийг зөрүүг 2023 оны төсөвт тусгасан/

Өмнөх оны дуусаагүй царцаагдсан барилгад төсөв батлахгүй дахин шинээр 2 сургуулийг шинээр барихаар төлөвлөн баталсан байна.

Иймд төсвийн төсөлд тусгах саналд 2019 оноос хойш дуусаагүй, царцаагдсан барилгын төсвийг улсын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

2.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна.

Санхүүжилтийг ТАХ-ний гүйцэтгэлийг үндэслэн холбогдох журмын дагуу олгосон байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь эрх шилжсэн ТАХ-ний санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын бодит гүйцэтгэлийг үндэслэн 14 төсөл, арга хэмжээнд 12,959.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 106.9 сая төгрөгийг БШУЯ-ны дансанд төвлөрүүлсэн, төсвийн санхүүжилтийн эрхийг бүрэн нээж шилжүүлсэн байна.

Хүснэгт 3: Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2022 онд олгосон төсвийн санхүүжилт /сая төгрөг/

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	2022 онд эрх нээсэн дүн	2022 онд ААНБ-д олгосон дүн	Татан төвлөрүүлсэн дүн
1	БШУС	4	23,644.8	5,280.0	4,318.8	4,211.9	106.9
2	ХХААХҮС	3	3,500.0	2,000.0	1,989.7	1,989.7	-
3	ЗГХЭГС	1	200.0	200.0	200.0	200.0	-
4	БХБС	1	1,600.0	1,600.0	1,591.7	1,591.7	-
5	ЗТХС	1	5,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	-
	ДҮН	10	33,944.8	10,080.0	9,100.2	8,993.3	106.9

Өмнөх онд орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн 4,084.5 сая төгрөгийн 14 ТАХ-ээс 2022 онд 9 ТАХ-нд 2,701.9 сая төгрөгийг захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын бодит гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

2013-2018 онд гэрээ байгуулж барилга байгууламжийг ашиглалтад хүлээж аваагүй 4 барилгад 2,583.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулжээ.

Шилжих хөрөнгөөр баталсан 2013-2018 онд гэрээ байгуулж барилга байгууламжийг ашиглалтад хүлээж аваагүй 4 барилгад 2,583.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулжээ. *Тухайлбал:*

- Сургуулийн барилга, 928 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэт цогцолбор сургууль/, /2013 онд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, анхны төсвөөр ажлыг гүйцэтгэх боломжгүй болж үнийн зөрүүг 2022 оны төсөвт нэмэлтээр баталсан/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/, /Геологийн дүгнэлт нь анхны баталсан зураг төсвөөс зөрүүтэй байсан тул барилгын суурийг төсөвт тусгасан хэмжээнээс их хэмжээгээр ухаж түүний үнийн зөрүүг БХТөвийн 1374/2020 дугаартай магадлалаар нэмэлт төсөв баталгаажуулж, 2022 оны

төсөвт баталсан/

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/, /Цэцэрлэгийн гадна тохижилтын ажил хийгдээгүй тул гадна тохижилтын төсвийг БХТөвийн 1716/2019 дугаартай магадлалаар нэмэлт төсөв баталгаажуулж 2022 оны төсөвт тусган баталсан/
- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/, /Барилга 2013 оноос хойш үргэлжлэн баригдаж байгаа бөгөөд БХТөвийн 299/2021 дугаартай магадлалаар нэмэлт төсөв баталгаажуулж, 2022 оны төсөвт баталсан/

Нэмэлт гэрээний төсвийг Барилгын хөгжлийн төв магадлан баталгаажуулж төсөвт тусгагдсан нь хуульд нийцэж байна.

2.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Барилга байгууламжийн чанарт анхаарч, захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос шилжсэн, 2021 онд хэрэгжиж эрх шилжсэн 12 төсөл, арга хэмжээнд ХББЗА ОНӨААТҮГ, эрх шилжээгүй 8 ТАХ-д аймгийн ГХБХБГ захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ. ГХБХБГ нь эрх шилжээгүй 8 ТАХ-д хэрэгжүүлсэн ажлын тайлан, явцын мэдээллийг зураг, тайлбартайгаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Аудитаар 2022 онд хэрэгжүүлсэн 55,253.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 ТАХ-г гүйцэтгэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт, түүний гүйцэтгэл, зөрчил дутагдлын биелэлтийг хэрхэн хангуулсан эсэхийг талбайн журнал, холбогдох бусад баримт материалын хүрээнд тулган баталгаажуулав.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэснээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад хяналтын инженерүүд, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, бараа материалын гарал үүслийн баримтыг орчуулж, сорьц дээжийг лабораторид шинжлүүлэх зэрэг үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралтын ажлын үе шат бүрд тавих хяналт хангалтгүйгээс өмнөх онд гарсан алдаа, зөрчил давтагдаж байгаа нь хяналтын инженерүүдийн хариуцлагатай холбоотой бөгөөд ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанаргүй гүйцэтгэхэд хүргэж байна. Аудитаар тулган баталгаажуулсан чанаргүй хийгдсэн 7 ТАХ-г дахин гүйцэтгүүлж, хүлээн авах албан шаардлага хүргүүлэв.

Зураг төсөв зохиосон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж зохиогчийн хяналтыг үе шат бүрт хэрэгжүүлэн, үүрэг даалгавар өгч алдаа зөрчлийг арилган ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын алба нь төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлдэггүй байна.

ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1-д “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ”, 5.1.3-д “төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал”, 5.2.4-д “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих” гэж зааснаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих төлөвлөгөөг 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Мөн аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64.1.2-д “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу хэлэлцэн баталсан төсвийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид “Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, төсөл арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах” гэсэн зөвлөмжийг “Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө /2016-2021 он/” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлт ирүүлэх хугацаа болоогүй байна.

2.5. Зарим төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах комисс хангалтгүй ажилласнаас чанаргүй барилга, дутуу тоног төхөөрөмж хүлээн авч байна.

Улсын комисс үүрэг даалгавар өгч, биелэлтийг үндэслэн барилга байгууламж ашиглалтад оруулж байгаа ч ашиглалтад орсон зарим барилга чанарын шаардлага хангахгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн шилжих үлдэгдлээр баталсан нийт 8 барилга байгууламжийг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Үүнээс 2022 онд 3 барилга байгууламж, 2020, 2021 онд ашиглалтад орсон 5 барилга байгууламж байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа урьдчилсан комисс болон улсын комиссоор үүрэг даалгавар өгч, түүний биелэлтийг үндэслэн улсын комисс ажиллаж, барилга байгууламжийг хүлээн авсан акт үйлдэн баталгаажуулжээ.

Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтыг аудитын явцад

үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/, /паар хагарсан, фасадын шил хагарсан, гражны хаалга онгойдоггүй, камерын нэгдсэн систем ажилладаггүй, явган зам нурсан, фасадын бэхэлгээ унасан/
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг /паар хагарсан, гадна том цонх нумарсан, 1 өрөөний цонх хагарсан, хананд цууралт өгсөн/
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/, /Хананд цууралт өгсөн, 2 паар цоорсон, гражны халаалтгүй, камерын нэгдсэн систем ажилладаггүй/
- Сургуулийн барилга, 928 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэт цогцолбор сургууль/, /2 худаг хөлдсөн, биеийн тамирын заалны шал зааг үүссэн, гал тогооны хэсэг мөөгөнцөртсөн, дээврээс дээд ангиуд руу ус алдсан/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/, /дулаан алдалт ихтэй, цахилгаан монтаж ил, барилгын залгаа хэсэгт цууралт үүссэн, Дээврээс ус алдаж дээд ангиуд руу орсон, ангиуд мөөгөнцөртсөн/
- Сум, багийн орчныг сайжруулах тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/, /Уг ажлыг 11 дүгээр сард хүлээн авсан, тарьсан мод хугарч, ургах чадваргүй болсон/

Улсын комисс акт үйлдэн барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа зарим тоног төхөөрөмж ажилладаггүй байхад хүлээн авсан, чанаргүй барилга хүлээн авсан нь ашиглалтын явцад харагдаж байна.

Иймд барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс чанартай барилга байгууламжийг хүлээн авах шаардлагатай байна.

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 28 ТАХ хэрэгжсэнээс 17 ТАХ-ний гэрээг дүгнэж, 9 ТАХ-ний гэрээ дүгнээгүй ба ТАХ дуусаагүй, 2 ТАХ нь эрх шилжээгүй тул мэдээллийг харах боломжгүй байна.

Гэрээ дүгнэсэн 17 ТАХ нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгожээ.

Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 3,973.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, 772.1 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Хөрөнгийн бүртгэлийг улсын комиссын актыг үндэслэн тухайн байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэрийг аймгийн Засаг дарга баталгаажуулдаг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн 28 ТАХ-ээс ОНӨГ-н дуусаагүй барилгын данс бүртгэлд 3,878.9 сая төгрөгийн 5 ТАХ, ашиглагч байгууллагын хөрөнгөд 28,560.9 сая төгрөгийн 16 ТАХ-г бүртгэж, 20,080.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 6,212.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан 7 ТАХ-г бүртгээгүй байна. Үүнээс ГХБХБГ хяналт хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээллийг Барилгын хөгжлийн төв болон харьяа яамдад хүргүүлдэг эрх шилжээгүй

10,610.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,238.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан 4 ТАХ байна.

Харин эрх шилжсэн тоног төхөөрөмж нийлүүлэх 9,470.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,498.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлтэй 3 ТАХ, “Олон талт түншлэл” цахим хөтөлбөрөөр нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс 475.8 сая төгрөг, нийт 3,973.8 сая төгрөгийн хөрөнгийг аль ч байгууллага бүртгээгүй зөрчилд албан шаардлага, 191.2 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд давхардуулан бүртгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Эрх шилжээгүй ГХБХБГ хяналт хэрэгжүүлсэн Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ нь 2022 онд ашиглалтад орсон ч баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар аль ч байгууллага бүртгээгүй байна.

Ашиглагч байгууллагад шилжүүлсэн 1,558.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг “тоног төхөөрөмж түрээслэх, ашиглуулах гэрээ” байгуулж иргэд болон төрийн байгууллагуудад олгожээ.

Харин огт бүртгэлд тусгаагүй 2 ТАХ-ээс 3,498.0 сая төгрөгийн 15 нэр төрлийн 1264 ширхэг тоног төхөөрөмжийг “тоног төхөөрөмж түрээслэх, ашиглуулах гэрээ” байгуулж иргэдэд олгосон байна. Тухайлбал:

- Олон талт түншлэлийг хөгжүүлэх “Жишиг баг” төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/,
- Олон талт түншлэлийн хүрээнд “Жишиг эко баг” төсөл /Орхон, Баян - Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/

Мөн 475.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг төрийн байгууллагад шилжүүлсэн гэх боловч тухай байгууллага данс бүртгэлдээ тусгаагүй байна.

Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтыг тулгахад 772.1 сая төгрөгийн 320 ширхэг тавилга эд хогшил, тоног төхөөрөмж зориулалтын дагуу ашиглаагүй, 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж биетээр байхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/411 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн ХХААГ нь үндсэн хөрөнгийн шинж чанартай 558.8 сая төгрөгийн 451 ширхэг тоног төхөөрөмжийг бараа материалын тусгай зориулалтын дансанд бүртгэсэн байна. Энэ нь хөрөнгийг 1-2 жил ашигласны дараа ТШЗ актлах шийдвэр гаргах, үр дүнгүй хөрөнгө оруулалт бий болох эрсдэлтэй байна.

Төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж биетээр байхгүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

ГУРАВ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хөрөнгийн бүртгэл болон он дамнан гүйцэтгэж буй ТАХ-нд анхаарах шаардлагатай байна.

3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг нэмэгдүүлэх, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтод нийцүүлж, орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

“Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох заалтуудад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг тулгахад 385 ТАХ-г нийцүүлэн төлөвлөжээ.

Үүнээс хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 186 төсөл арга хэмжээг төсөл хөтөлбөр нэрээр баталдаг байна.

Мөн зураг төсвийн зардал болон болзошгүй аваарын зардлыг төсөвт багцалсан дүнгээр баталдаг байна. /зураг төсөв-10, болзошгүй аваарын зардал-52 ажил болон задарсан. Дэлгэрэнгүй мэдээллийг ОНХО-н судалгаанд харуулсан болно/

Аймгийн ИТХ-н тогтоолыг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09/05 дугаар тогтоол, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10/02 дугаар тогтоол, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор нийт 3 удаа тодотгожээ.

Хүснэгт 4. Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн /сая.төг/

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Анх баталсан /2021.12.02/		Тодотгож баталсан /2022.05.03/		Тодотгож баталсан /2022.07.07/		Тодотгож баталсан /2022.09.15/		Зөрүү /өсөлт+, бууралт-/	
		ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн
1	Шилжих	47	9,783.4	46	15,069.9	46	15,069.9	46	15,069.9	-1	5,286.50
2	Шинэ	308	43,532.8	329	45,647.7	341	44,643.7	339	44,643.7	31	1,110.90
Нийт дүн		355	53,316.2	375	60,717.6	387	59,713.6	385	59,713.6	30	6,397.40

Анх баталсан тогтоолоос сүүлд тодотгон батлахдаа шилжих хөрөнгө оруулалтын ТАХ-ний тоог нэгээр бууруулсан ч санхүүжүүлэх дүн 5,286.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний тоог 30-аар нэмэгдүүлж, санхүүжүүлэх дүнг 1,110.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үүнээс харахад хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим ТАХ-г анх батлахдаа оновчтой бус, тооцоо судалгаагүй төлөвлөж байгааг илтгэж байна.

2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 385 ТАХ-ний 65 ТАХ буюу 16.9 хувь нь барилга байгууламж, 20 ТАХ буюу 5.2 хувь нь их засварт, 93 ТАХ буюу 24.2 хувь нь тоног төхөөрөмж, 21 ТАХ буюу 5.5 хувь нь зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, 186 ТАХ буюу 48.3 хувь нь төсөл хөтөлбөрт төлөвлөсөн байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хийгдсэн ТАХ нийт баталсан хөрөнгө оруулалтын тоонд эзлэх хувь



Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нийт 199 байгаагаас Болзошгүй аваарын зардал, Зураг төсвийн зардлыг багцлан төсөвлөсөн бөгөөд Болзошгүй аваарын зардал 52 арга хэмжээ, зураг төсвийн зардал 10 арга хэмжээ болж задарсан байна.

Төсөл, арга хэмжээг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн баталсан ч тооцоо судалгаатай ТАХ-г төсөвлөж батлах шаардлагатай байна.

3.2. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн боловч иргэдээс авах саналын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орхон аймгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах” гэж заасны дагуу төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, зураг төслийг үндэслэн төлөвлөсөн байна.

Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 21 багийн иргэдтэй уулзалт хийж, мэдээлэл өгч, хөрөнгө оруулалт, их засвартай холбоотой 68 багц арга хэмжээнд давхардсан тоогоор 503 иргэнээс санал хүлээн авчээ.

Орхон аймгийн erdenet.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санал асуулга авахад гэр бүлийг төлөөлж 94 иргэнээс 15 санал ирүүлжээ.

Иргэд болон төсвийн шууд захирагчдаас ирүүлсэн саналыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нэгтгэн эрэмбэлж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, саналыг боловсруулсан байна.

Иргэдээс авсан саналыг аймгийн нийт хүн амын тоотой харьцуулахад хангалтгүй байгаа тул хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатанд иргэдээс авах саналын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд түүнээс хойших тодотголоор нэмэгдэж баталсан ТАХ-г тус хуульд нийцсэн эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Тодотгосон төсөвт нэмэгдсэн 30 ТАХ баталснаас 9 ТАХ -г НТШ журмаар 2022 оны 05 дугаар сарын 10-аас 2022 оны 11 сарын 15-ны хооронд зохион байгуулсан. Хугацаандаа хэрэгжих боломжгүй 4 ТАХ-ний гэрээ хийгдээгүй 2023 онд хийгдэхээр хойшилсон байна.

Шууд худалдан авалт хийсэн 37 төсөл арга хэмжээ тайлант онд 894.0 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй байснаас гүйцэтгэлээр 819.2 сая төгрөг олгож, 74.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь он дамнан гүйцэтгэж байгаа, санхүүжилт болон хөрөнгийн бүртгэл хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөө буурч байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн 97.7 хувьтай зохион байгуулжээ.

Хөрөнгө оруулалтын 94 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 12 үнэлгээний хороо байгуулжээ.

Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Үнэлгээний хороод тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 66,390.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 261 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 54,963.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын, 2,614.4 сая төгрөгийн төсөвтэй 50 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 2,635.3 сая төгрөгийг төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын дагуу, 3,467.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 88 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар зохион байгуулсан байна. Шилжих үлдэгдлээр баталсан 2,806.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээ нь Засаг даргын шийдвэрээр, 1 төсөл, арга хэмжээ нь зураг төсөв алдаатай дахин хийгдэх шаардлагатай тул 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс тус тус хассан, 4 ТАХ нь өмнөх ондуудад худалдан авах ажиллагаа зарлагдаж, гэрээ байгуулсан ч ажил дуусаагүй хойшлогдсон байна.

Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалаар баталсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын 1.44-т заасны дагуу аймгийн ОНӨГ нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалт болон

харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа цахим системийг ашигласан байна. 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төрлөөр харуулбал:

Хүснэгт 5: ОНХО-аар хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны төрөл

Хөрөнгө оруулалтын төрөл	Ажлын тоо	Үүнээс			
		НТШ	ХА	ШХА	ЗҮ
Барилга, байгууламж	65	43	17	5	-
Их засвар	62	19	1	40	-
Тоног төхөөрөмж	104	30	32	41	-
Зураг төсөв	30	2	1	2	23
Нийт	261	94	50	88	23

2022 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийт ТАХ-ээс худалдан авах ажиллагаа биелэгдээгүй ТАХ байхгүй байна.

2022 онд тендерт оролцогчдоос 6 гомдол гаргасан байна. Сангийн яаманд 6 гомдол хянагдаж, 2 тендерт захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 2 тендерт захиалагчийн хяналтыг үндэслэлгүй, 2 тендерийг хүчингүй болгосон байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Зууны мэдээ сонин, гадаад хэл дээр UB post сонинд нийтлүүлэн, erdenet.mn, tender.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангажээ.

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, улирал бүр тайлагнаж, erdenet.mn цахим хуудсанд мэдээлжээ. Төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг бүрэн бүрдүүлж, архивын нэгж болгожээ.

2022 онд орон нутгийн төсвийн худалдан авалтаас 3,016.9 сая төгрөгийн хэмнэлт бий болжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр он дамнан гүйцэтгэж байгаа ТАХ болон бэлэг дурсгалын зүйлд 219.9 сая төгрөгийг зарцуулсан нь хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бууруулж байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 199, болзошгүй аваарын зардал 52, зураг төсвийн зардал 10 ТАХ нийт 261 ТАХ-ний 78 хувь буюу 201 гэрээг 100 хувьтай, 12 хувь буюу 29 гэрээний хэрэгжилт хангагдаагүй дутуу, үлдсэн 12 хувь буюу 29 гэрээ огт дүгнээгүй гүйцэтгэл 2023 онд болж хойшилсон байна.

Гэрээний хэрэгжилт хангагдаагүй дутуу 29 ТАХ-ний ажлын гүйцэтгэл 19-98 хувьтай хэрэгжсэн их засвар, барилга байгууламжууд байна.

ТАХ-ний гүйцэтгэлийн болон санхүүжилтийн баримт материалуудыг тулган баталгаажуулахад зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж, холбогдох төрийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хүлээн авсан нэг төсөл арга хэмжээний тоног төхөөрөмжийн чанар муу, зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлсэн байна.

Иймд тоног төхөөрөмж хүлээн авахдаа зах зээлийн үнэ болон чанарын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж хүлээн авч байхыг зөвлөж байна.

Аймгийн ЗДТГ-ын хүндэтгэл үзүүлэх 150.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын хүндэтгэл үзүүлэх 69.9 сая төгрөг нийт 219.9 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Барилга угсралт, их засварын ажлын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэж олгосон ч тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй 2 ТАХ-нд санхүүжилт олгожээ.

Аймгийн ИТХ-аар 2022 онд олгохоор баталсан 49,499.5 сая төгрөгөөс гүйцэтгэгчид 40,781.2 сая төгрөгийг захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын бодит гүйцэтгэлийг үндэслэн олгож, орон нутгийн техник хяналтын болон барьцаа хөрөнгийн дансанд 1,582.2 сая төгрөгийг суутган төвлөрүүлж, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8,136.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Санхүүжилтийг гэрээнд тусгасны дагуу баталгаажсан барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

Харин тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй, хүлээн авах комиссын акт үйлдээгүй 2 ТАХ-ний гүйцэтгэх гэрээг үндэслэн 19.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь санхүүжилтэд тавих хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Иймд гэрээний үүргээ биелүүлээгүй байхад санхүүжилт олгосонд аймгийн Засаг даргын Тамгын газарт төлбөрийн акт тогтоосон.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн ч он дамнан гүйцэтгэж буй ТАХ-нд анхаарах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ болон Хотын захирагчийн алба тус тус хэрэгжүүлжээ.

ХББЗА ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн нийт 86 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж, 70 төсөл, арга хэмжээнд улсын комисс ажиллан ашиглалтад оруулж, 3 төсөл, арга хэмжээнд техникийн комисс ажиллаж, 13 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр болсон байна. Шилжих үлдэгдлээс санхүүжих 14 ТАХ-нд улсын комисс ажиллаагүй, хүлээн аваагүй байна.

Хотын захирагчийн алба нь аваарын зардлаар гүйцэтгэж буй нийт 34 ажилд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийг баримталж, барилга угсралтын ажилд хяналтыг хэрэгжүүлэн, ил, далд ажлыг актаар баталгаажуулан, барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэснээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад хяналтын инженерүүд, зураг төсөв зохиогчид хөдөлмөр хамгааллын дүрмийг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал

баталгаажуулж байх, бараа материалын гэрчилгээг орчуулж, сорьц дээжийг лабораторид шинжлүүлэх зэрэг үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгч байгууллагууд хэрэгжүүлж, ил далд ажлын акт үйлдэн, захиалагч, зохиогч нараар хянуулж, фото зургаар баталгаажуулсан байна.

Илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч удааширч буй ажлуудад анхаарахаар байна.

ТАХ-ний хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, тоног төхөөрөмжийг чанарын шаардлагад нийцсэн, тоо ширхгийн дагуу бүрэн хүлээж авах шаардлагатай байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн 261 ТАХ-ээс орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэж, тайлагнасан эсэхийг ТАХ-ний гүйцэтгэлтэй тулгахад 201 ТАХ бүрэн дуусаж өмчид бүртгэхээр, 14 ТАХ-г дуусаагүй барилгад бүртгэхээр байна.

Үүнээс 2022 онд хэрэгжиж дууссан 26,068.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 183 ТАХ-г бүртгэсэн бөгөөд хүлээн авсан 578.6 сая төгрөгийн 13 их засвар, тоног төхөөрөмж, 663.9 сая төгрөгийн 7 зураг төсөв бүртгээгүй тул хөрөнгөд бүртгэх албан шаардлага хүргүүлээ.

Зураг төсөв хүлээн авах комисст Орон нутгийн өмчийн газар оролцдоггүйгээс шалтгаалж хөрөнгөд бүртгээгүй, алдаа зөрчил дахин давтан гарсан байна.

Мөн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хавсралтад тусгасан тоног төхөөрөмж дутуу нийлүүлсэн байхад “Тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт”-г үйлдсэн, зах зээлийн ханшнаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Дутуу нийлүүлсэн тоног төхөөрөмжтэй холбоотой зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөрчил дахин давтан гарсан, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 4,637.7 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж бүртгээгүй, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хавсралтад тусгасан тоног төхөөрөмж дутуу нийлүүлсэн байхад “Тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт”-г үйлдсэн тул холбогдох мэргэжилтэнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Төсөл арга хэмжээг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан ч зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ баталдаг зөрчил давтан гарсаар байна.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байна.
- Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах комисс хангалтгүй ажилласнаас чанаргүй барилга, дутуу тоног төхөөрөмж хүлээн авч байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг нэмэгдүүлэх, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.
- Зарим төсөл арга хэмжээ он дамнан хэрэгжиж байгаа, санхүүжилт болон хөрөнгийн бүртгэл хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөө буурч байна.

Аудитаар нийт 6,187.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 437.7 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 5,749.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 3 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт толилуулах

- Царцаагдсан барилга болон он дамнан хэрэгжиж байгаа ТАХ-г дуусгаж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар нэгдсэн тайланд тусгах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 2019 оноос баригдаж эхэлсэн одоог хүртэл дуусаагүй барилгыг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар тодорхой ажил зохион байгуулах,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст

- ОНХО-аар хэрэгжих ТАХ-нд иргэдийн саналыг нэмэгдүүлэх.

Орон нутгийн өмчийн газарт

- Техникийн тодорхойлолтод нийцсэн чанарын шаардлага хангасан тоног төхөөрөмж хүлээж авах,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 191.2 сая төгрөгийн хөрөнгийг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт бүртгэсэн давхардлыг арилгах,

Хотын захирагчийн албанд

- Болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн ажлын баримт материалыг ОНӨГ-т хүлээлгэн өгч байх.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт

- Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын мэдээлэл, ашиглалтад орсон барилга байгууламжийн холбогдох баримт материал, мэдээллийг ОНӨГ-т хүргүүлж байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Б.БЯМБАТОГТОХ
Г.ДАВААСҮРЭН
Ц.ОДГЭРЭЛ

Холбогдох байгууллагын санал



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2023.05.02 № 01/1111
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн хариу тайлбарыг хүргүүлэв.

Хавсралт¹⁶ хуудастай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ



Б. Бямбаагмог

Аудитагч

2/02

6123021141

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын
06-ний өдрийн 4/11/2023 тоот албан тоотын хавсралт

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн хариу тайлбар

Д/д	Агуулга	Тайлбар
1	Олон талт түншлэлийг хөгжүүлэх Жишиг баг төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/, Олон талт түншлэлийн хүрээнд Жишиг эко баг төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг” Сэхүүн чоно ХХК-н нийлүүлсэн 3,498.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аль ч байгууллага бүртгээгүй байна. Яагаад бүртгээгүй вэ?	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022/552 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн 2,180,420,000 төгрөгийн, 2022/551 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн 1,727,168,300 төгрөгийн, нийт 3,907,588,300 төгрөгийн хөрөнгийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр ХХААГ-т бараа хүлээн авах актаар хүлээлгэн өгсөн. Хөрөнгө хүлээлгэн өгөхөд гутлын толгой хэвлэх 48 ширхэг машин дутуу буюу нийлүүлэгдээгүй болно. Компаний зүгээс бид уг хөрөнгийг захиалсан байгаа жилийн эцэс болоод Улсын төсвийн хөрөнгө оруулалт татагдах гээд байгаа тул санхүүжилтыг бүрэн авах шаардлагатай байна гэсэн хүсэлтийг аймгийн Засаг даргад гаргасан байсан. Холбогдох удирдах албан тушаалтнуудын хүрээнд ярьж зөвшилцөөд гутлын толгой хэвлэх 48 ширхэг машин нь 2023 оны 02 дугаар сард нийлүүлэгдэх тул хөрөнгийг бүрэн хүлээн авснаар бараа хүлээн авах актыг үйлдэхийг чиглэл болгосон. Хөрөнгийг ХХААГ-т актаар хүлээлгэн өгсөн хэдий ч БӨЗДТГ тараах болж БӨЗДТГ-ын нярав Дөлгөөн хөрөнгийг жагсаалтаар хүлээн авч гарын үсэг зурсан байна. ОНӨГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 08 тоот албан бичгээр хөрөнгө хүлээн авсан акт, зарлагын баримтыг цаасаар болон и-оффиссоор хүргүүлсэн байна. БӨЗДТГ-ын нягтлан бодогч А.Адъяадолжин албан бичгийг шийдвэрлэхдээ 2022 оны санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэн авсан гэж и-оффис системд хаасан байна. ХХААГ-ын хөрөнгө хүлээн авсан тушаал, БӨЗДТГ-ын няравын хөрөнгө хүлээн авсан жагсаалт, Сэхүүн чоно ХХК-ийн албан тоот, ОНӨГ-ын албан тоотыг хавсаргав.
2	Төрийн үйлчилгээг ил тод нээлттэй болгох Олон талт түншлэл цахим хөтөлбөр /Орхон/ Баганадант ХХК-ний	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ОР-163/2021 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн 702,856,000 төгрөгийн хөрөнгийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр АЗДТГ-т,

	нийлүүлсэн 475.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж аль ч байгууллагад бүртгэлгүй байна. Яагаад бүртгээгүй вэ?	1,061,082,000 төгрөгийн хөрөнгийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ХХААГ-т актаар хүлээлгэн өгсөн. ОНӨГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 08 тоот албан бичгээр хөрөнгө хүлээн авсан акт, зарлагын баримтыг цаасаар болон и-оффиссоор хүргүүлсэн байна. БӨЗДТГ-ын нягтлан бодогч А.Адъяадолжин албан бичгийг шийдвэрлэхдээ 2022 оны санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэн авсан гэж и-оффис системд хаасан байна. БӨЗДТГ 475.8 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ-дад өгсөн байна. Энэ нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 49 дүгээр тогтоолын 5.2 дахь заалтад “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг орон нутгийн өмчит байгууллагуудын хооронд шилжүүлэх асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ” гэснийг зөрчиж хөрөнгө шилжүүлэх тухай саналыг ОНӨГ-т ирүүлж шийдвэрлүүлээгүй байна.
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх 2-төсөл арга хэмжээнээс 48 ширхэг гутлын толгой хэвэлгээний машиныг нийлүүлээгүй байтал тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт үйлдсэн. Тоног төхөөрөмж одоог хүртэл нийлүүлэгдээгүй. Хүүхдийн хөгжил төслийн хүрээнд сургуулиудын биеийн тамир, технологи, урлагийн боловсрол олгох кабинет байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах 3,075.0 мянган төгрөгийн 6 ширхэг толь ирээгүй байхад тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын акт үйлдсэн байна. Яагаад биетээр ирээгүй хөрөнгийг хүлээн авах акт үйлдэн хүлээж авсан бэ?	Сэхүүн чоно ХХК гутлын толгой хэвэлгээний 409.5 сая төгрөгний 48 ширхэг машиныг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр нийлүүлнэ гэсэн аймгийн Засаг даргын цохолттой албан тоотыг өгсөн. 2023 оны 1 дүгээр сард дутуу хөрөнгө хугацаандаа нийлүүлэгдэх талаар компанируу 3-4 удаа ярьж сануулсан. Гааль дээр хүнсний бараа бүтээгдэхүүнийг эхний ээлжинд оруулж байгаа тул хүлээгдэж байна гэсэн хариуг өгч байсан. Хүүхдийн хөгжил төслийн хүрээнд сургуулиудын биеийн тамир, технологи, урлагийн боловсрол олгох кабинет байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл хүлээн авах комисс ажиллахад сургуулиуд өөрсдийн шаардлагын дагуу 3,075.0 мянган төгрөгийн 6 ширхэг толийг зүсүүлж хийлгэнэ гэсэн санал гарсан. Дутуу хийгдсэн хөрөнгийг хийж дуусгасан болно гэсэн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 609 тоот албан бичгийг БШУГ-аас ирүүлсний үндсэн дээр ОНӨГ хөрөнгийн санхүүжилт олгох тухай албан тоотыг өгсөн. БШУГ-ын албан тоотыг хавсаргав.
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркын ТЭЗҮ боловсруулах	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркын ТЭЗҮ боловсруулах 5,000.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан.

	төсөл арга хэмжээгээ тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Энэ тоног төхөөрөмжийг танай байгууллагаас авахгүй гэсэн шаардлага тавьсан ч ЭШУТП хүлээж авсан байна. Энэ талаар танай байгууллага ямар хяналт хэрэгжүүлсэн бэ?	2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр бараа хүлээлгэн өгөх хүсэлтийг Воком констранкшн ХХК ирүүлсэн. Хөрөнгийг газар дээр нь очиж үзэхэд 800.0 сая төгрөгийн хөрөнгө ирсэн гээд жагсаалт үзүүлсэн /компьютер, контейнер, хүлэмж, оёдлын машин/. Компьютер, хүлэмжний үнэ зах зээлийн үнээс хэт өндөр байсан тул манай байгууллагын зүгээс ийм өндөр үнэтэй хөрөнгийг хүлээн авах боломжгүй гэж хэлсэн. Ашиглагч байгууллагыг хөрөнгийн зах зээлийн үнийг судалж танилцуулахыг мэдэгдсэн. Хөрөнгийн санхүүжилтыг олгогдоогүй болно. ЭШУТП 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй хэдий ч иргэдэд тараасан байна. ЭШУТП-ын албан тоотыг хавсаргав.
5	Өмнөх Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг гүйцэтгэлийн аудитаар Зөвлөх үйлчилгээний 344.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг биет бус хөрөнгөд бүртгээгүй байна гэсэн албан шаардлага хүргүүлсэн ч энэ онд алдааг дахин давтаж 663.9 сая төгрөгийн 7 зөвлөх үйлчилгээг бүртгээгүй байна.	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн зураг төсвийг биет бус хөрөнгөд бүртгээгүй албан шаардлагын дагуу зөрчлийг 2022 онд аймгийн Засаг даргын захирамж гаргаж арилгасан. 2022 онд хийгдсэн зураг төсвийн ажлуудыг харъяалагдах байгууллагуудын санхүүгийн тайланд хүлээн авсан бөгөөд 663.9 сая төгрөгийн 7 зөвлөх үйлчилгээ нь ТЭЗҮ боловсруулах ажлууд байгаа бөгөөд зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах ажлын гэрээ байгуулах, хүлээн авах ажиллагаанд манай байгууллагыг оролцуулахгүй байгаа нь хөрөнгө бүртгэн авах ажилд хүндрэл үүсгэж байна. НББ-ын анхан шатны баримт байхгүй, зураг төсөв, ТЭЗҮ-н ажлын гүйцэтгэлийн баримт бичиг байхгүйгээс хөрөнгийг бүртгэлд авах боломжгүй. Санхүү төрийн сангийн хэлтэс бараа, ажил дээр санхүүжилтын гүйлгээ хийхдээ ОНӨГ-аас санхүүжилт олгох тухай албан тоот авдагтай адил зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилтыг олгохдоо албан тоот авч байх шаардлагатай байна.
6	Шинэ эрдэнэт концерциум ХХК-н нийлүүлсэн Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмжийг аймгийн ХХААГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ гэсэн 3 байгууллага дээр 191.2 сая төгрөгийг бүртгэсэн байна.	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмжийг ажлын хэсгийн хурал дээр анх Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ-т хүлээлгэн өгье гэсэн шийдвэр гарч хөрөнгийг 2 суманд хүлээлгэн өгсөн. Хөрөнгийг Баян-Өндөр, Жаргалант суманд хүлээн авч бүртгэсний дараа ХХААХҮЯ-ны сайдын тушаал гарч хөрөнгийг ХХААГ-т хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.

		Энэ нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 49 дүгээр тогтоолын 5.2 дахь заалтад “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг орон нутгийн өмчит байгууллагуудын хооронд шилжүүлэх асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ” гэснийг зөрчиж хөрөнгө шилжүүлэх тухай саналыг ОНӨГ-т ирүүлж шийдвэрлүүлээгүйгээс үүссэн. ХХААГ нь төрийн өмчит байгууллага тул хөрөнгө орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд нэгтгэгдэдгүй тул хөрөнгийг давхар бүртгэсэнд хяналт тавиагүй байна.
7	Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 20,080.3 сая төгрөгийн 7 ТАХ-г бүртгээгүй.	БХБС-ын багцаас хийгдсэн Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваатт, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/-ын ажлыг 2.0 тэрбум төгрөгийн, БШУС-ын багцаас хийгдсэн Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/-н 800.0 сая төгрөгийн ажлуудад Улсын комисс ажиллаагүй, БШУС-ын багцаас хийгдсэн Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/-н 1.6 тэрбум төгрөгийн ажилд Улсын комисс ажилласан боловч ашиглалтад хүлээн аваагүй, БШУС-ын багцаас хийгдсэн ЭШУТП-ийн ТЭЗҮ-н үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/-ийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө нийлүүлэгдээгүй байгаа, ЗТХС-ын багцаас хийгдсэн Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/ зам нь улсын чанартай автозам тул өмчлөгч нь ТӨБЗГ, эзэмшигч байгууллага нь Орхон АЗЗА ТӨХК болно. Харьяалах яамдуудаас эрх шилжиж ирээгүй болон хөрөнгийн гүйцэтгэлийн баримт бичиг бүрэн ирээгүй, улсын комиссын акт гараагүй анхан шатны баримт байхгүй тул хөрөнгөд бүртгэх боломжгүй. 2022 оны санхүүгийн тайланд бүртгэлгүй хөрөнгө гэж үзэхгүй.
8	Орон нутгийн төсвийн аваарын зардлаар нийлүүлсэн хөрөнгийг бүртгэж аваагүй.	Аваарийн зардлаар хийсэн ажлын гүйцэтгэлийн баримт материалыг ХЗА-аас ОНӨГ-т тухай бүр гаргаж ирүүлээгүй учраас хөрөнгийн анхан шатны баримт байхгүй тул хөрөнгийг бүртгэн авах боломжгүй байна.

Саналд өгсөн тайлбар:

1. Олон талт түншлэлийг хөгжүүлэх “Жишиг баг” төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/, Олон талт түншлэлийн хүрээнд “Жишиг эко баг” төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/-т Сэхүүн чоно ХХК-н нийлүүлсэн 3,498.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийг аудитын явцад холбогдох байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад данс бүртгэлд тусгаагүй байна. Аудитын явцад ОНӨГ-аас ашиглагч байгууллагад хөрөнгөд бүртгэх тухай албан бичиг хүргүүлсэн эсэхийг тодруулахад хүргүүлсэн албан бичгийг ирүүлээгүй бөгөөд тус тайлбартай холбоотой асуудлаар аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.
2. Төрийн үйлчилгээг ил тод нээлттэй болгох Олон талт түншлэл цахим хөтөлбөр /Орхон/-ийн хүрээнд Баганадант ХХК-н нийлүүлсэн 475.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь аймгийн ИТХТ-н 2017 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах журам”-ын 4.3-д “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хүрээнд шинээр бий болсон, төрийн өмчөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн ашиглагч байгууллага нь тодорхойгүй байгаа эд хөрөнгийг Орон нутгийн өмчийн газар хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргатай зөвшилцөн эзэмшигч, ашиглагч байгууллагыг тогтоож, хөрөнгийг хүлээлгэн өгнө” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд аудитын тайланд тус тайлбартай холбоотой өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх 2 төсөл арга хэмжээнээс 48 ширхэг гутлын толгой хэвэлгээний машиныг нийлүүлээгүй байтал хүлээн авах комиссын акт үйлдсэн. Тоног төхөөрөмж одоог хүртэл нийлүүлээгүй нь аудитын явцад нотлогдсон. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.4-д “Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, хавсралт №11-д заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана” гэж заасантай нийцэхгүй байна.
“Хүүхдийн хөгжил төслийн хүрээнд сургуулиудын биеийн тамир, технологи, урлагийн боловсрол олгох кабинет байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах” 3,075.0 мянган төгрөгийн 6 ширхэг толь ирээгүй байхад тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын акт үйлдсэн байна. Аудитын баг аудитын явцад ашиглагч байгууллагаар явж тулгалт хийхэд 2023 оны 04 дүгээр сар хүртэл нийлүүлэгдээгүй байна. Энэ нь

"Хүүхдийн хөгжил төслийн хүрээнд сургуулиудын биеийн тамир, технологи, урлагийн боловсрол олгох кабинет байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл" /Багц-3 Биеийн тамирын хэрэгсэл/ худалдан авах ОРАОНӨГ/202212116 дугаар гэрээний 2.2-д "Захиалагч барааг хүлээн авсны дараа актыг үндэслэн нийлүүлэгчид төлбөрийг 100 хувиар олгоно" гэж заасантай нийцэхгүй байна. Иймд аудитын тайланд тус тайлбартай холбоотой өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн ТЭЗҮ боловсруулах төсөл арга хэмжээгээр тоног төхөөрөмж нийлүүлсэн ч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”, 4.4-д "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана" гэж заасантай нийцэхгүй байна. Иймд аудитын тайланд тус тайлбартай холбоотой өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
5. Өмнөх “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар зөвлөх үйлчилгээний 344.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг биет бус хөрөнгөд бүртгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн ч алдаа зөрчил дахин давтан гарч 663.9 сая төгрөгийн 7 зөвлөх үйлчилгээг бүртгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.3-д "Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны

дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”, 4.4-д “Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд аудитын тайланд тус тайлбартай холбоотой өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

6. Шинэ эрдэнэт консерциум ХХК-н нийлүүлсэн Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих 191.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн ХХААГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ гэсэн 3 байгууллага давхар бүртгэсэн байна. Энэ нь аймгийн ИТХТ-н 2017 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах журам”-ын 4.3-д “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хүрээнд шинээр бий болсон, төрийн өмчөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн ашиглагч байгууллага нь тодорхойгүй байгаа эд хөрөнгийг Орон нутгийн өмчийн газар хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргатай зөвшилцөн эзэмшигч, ашиглагч байгууллагыг тогтоож, хөрөнгийг хүлээлгэн өгнө” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд аудитын тайланд тус тайлбартай холбоотой өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим хөрөнгийг бүртгээгүй талаар аудитын тайланд “20,080.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 6,212.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан 7 ТАХ-г бүртгээгүй байна. Үүнээс ГХБХБГ хяналт хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээллийг Барилгын хөгжлийн төв болон харьяа яамдад хүргүүлдэг эрх шилжээгүй 10,610.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,238.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан 4 ТАХ байна. Харин эрх шилжсэн тоног төхөөрөмж нийлүүлэх 9,470.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,498.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлтэй 3 ТАХ, “Олон талт түншлэл” цахим хөтөлбөрөөр нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс 475.8 сая төгрөг, нийт 3,973.8 сая төгрөгийн хөрөнгийг аль ч байгууллага бүртгээгүй зөрчилд албан шаардлага, 191.2 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд давхардуулан бүртгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.” гэж өөрчлөлт оруулав. Мөн ГХБХБГ-т эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын мэдээлэл, ашиглалтад орсон барилга байгууламжийн холбогдох баримт материал, мэдээллийг ОНӨГ-т хүргүүлж байх зөвлөмжийг аудитын тайлангийн зөвлөмж хэсэгт нэмж тусгав.
8. Орон нутгийн төсвийн болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн ажлыг хөрөнгөд бүртгээгүй нь анхан шатны баримтын бүрдэл дутуугаас шалтгаалсан тул аудитын тайлангийн зөвлөмж хэсэгт Хотын захирагчийн албанд болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн ТАХ-ний баримт материалыг ОНӨГ-т хүргүүлж, ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгэхийг зөвлөмжөөр тусгав.